

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ГАДААД
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА БИНДЭРЬЯА ОВОГТОЙ ЯНЖМААГИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа
	1	2	3	4	5	6
Зорилт 1. “КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД						
1.	КОВИД-19 цар тахлын халдвартай тэмцэх хариу арга хэмжээнд олон улсын дэмжлэг, туслалцаа авах, эм, эмнэлгийн болон хувийн хамгаалах хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх	Бүрдүүлсэн нөөц, санхүүжилтийн хэмжээ	2023 онд 4,04 тэрбум төгрөгийн нөөцийг буцалтгүй тусламжийн хөрөнгөөр бүрдүүлсэн.	Салбарын хариу арга хэмжээнд шаардлагатай нөөцийг гадаад эх үүсвэрээс нэмэгдсэн байна.	2024 оны эхний хагас жилийн байдлаар гадаад хамтын ажиллагааны хүрээнд КОВИД-19 цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнд хэрэглэх нөөцөд нийт 2,907,500,688 төгрөгийн үнэ бүхий эм, эмнэлгийн хэрэгслийг буцалтгүй тусламжийн хөрөнгөөр бүрдүүлсэн. Үүнд: 1. Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)-аас Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламжийн хүрээнд олгосон 147,314,650 төгрөгийн үнэ бүхий насанд хүрэгчдийн болон хүүхдийн	2024.01.02-12.31

6.26



					амьсгалын хүрээг хүлээн авч Эрүүл мэндийн сайдын А/30 дүгээр тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. 2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаас буцалтгүй тусламжийн хүрээнд 2,710,720,000 төгрөгийн үнэ бүхий хувийн хамгаалах хэрэгслийг захиалан хүлээн авч Эрүүл мэндийн сайдын А/169 дүгээр тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. 3. Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID)-аас Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламжийн хүрээнд олгосон 49,466,038 төгрөгийн үнэ бүхий Vyaire LTV 200 загварын амьсгалын аппаратын засвар, үйлчилгээний хэрэгслийг Эрүүл мэндийн сайдын А/365 дугаар тушаалаар орлогод авсан.	
--	--	--	--	--	--	--

Зорилт 2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1 Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

Зорилт 2. “ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

1.	Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр эрүүл мэндийн байгууллагуудыг орчин үеийн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах	Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо	2023 онд гадаадын буцалтгүй тусламжийн хүрээнд	Эрүүл мэндийн байгууллагууд шаардлагатай тоног төхөөрөмжөөр	2024 оны жилийн эцсийн байдлаар гадаадын буцалтгүй тусламжийн хүрээнд 1,998,918,076 төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног	2024.01.02-12.31
----	---	--	--	---	--	------------------

120

			14,4 тэрбум төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ийг хүлээн авч, эрүүл мэндийн байгууллаг уудад хуваарилс ан.	хангагдсан байна	төхөөрөмжийг хүлээн авч, эрүүл мэндийн байгууллагуудыг хангав. Үүнд: 1. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сангаар дамжуулан "КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх" хөтөлбөрийн хүрээнд 183,499,890 төгрөгийн үнэ бүхий 30 ширхэг дуслын автомат шахуурга, 120 ширхэг тарианы автомат шахуургыг хүлээн авч Эрүүл мэндийн сайдын А/31 дүгээр тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. 2. Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлагийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаар дамжуулан 91,039,050 төгрөгийн үнэ бүхий 14 ширхэг дуслын автомат шахуурга, 74 ширхэг тарианы автомат шахуургыг худалдан авч, Эрүүл мэндийн сайдын А/31 дүгээр тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. 3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн санг хүсэлт, захиалга өгсний дагуу	
--	--	--	---	---------------------	--	--



					буцалтгүй тусламжийн хүрээнд 1,724,379,136 төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг хүлээн авч Эрүүл мэндийн сайдын А/463 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад олгосон.	
2.	<u>ЗГҮАХ 2.1.2.2</u> Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулна. <u>ГХХ:</u> Д вируст гепатитын халдварын эсрэг Булевиртид эмийн эмчилгээнд иргэдийг хамруулах нөхцөл, боломжийг бүрдүүлэх талаар АНУ болон ОХУ-тай яриа хэлэлцээг хийж, үр дүнд хүргэх	Яриа хэлэлцээний үр дүн	-	АНУ-ын үйлдвэрлэгчээс нийлүүлэх эмийн үнийн хөнгөлөлт, үнэ зэргийг тодорхой болгосон байна. ОХУ-д монгол иргэд эмчлүүлэх эрүүл мэндийн байгууллагыг судлаж тодорхой болгосон байна.	Булевиртид эмийн эмчилгээнд монгол иргэдийг хамруулах талаар ОХУ болон АНУ-тай яриа хэлэлцээг хийсэн. ОХУ-ын БНБурУ-ын төрийн хэвшлийн "СПИД" халдварт өвчний төв, хувийн хэвшлийн "Диагрупп" эмнэлэгт монгол өвчтнийг хүлээн авч эмчлэх боломжтойг тодорхойлсон. ОХУ-ын талаас үнийн тодорхой хөнгөлөлтийг үзүүлэхээр хоёр улсын Эрүүл мэндийн сайд нарын уулзалтын үеэр тохиролцсон. Гэсэн хэдий ч эмчилгээ удаан хугацаанд ОХУ-д хийлгэх нөхцөлтэй тул иргэдэд учрах санхүүгийн дарамт улам нэмэгдэх учраас яриа хэлэлцээг АНУ-ын "Гилеад Сайэнсис Инк" компанитай үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн. Энэ хүрээнд 5 удаагийн цахим уулзалт, 48 цахим шуудан, 2 албан бичиг харилцан солилцсоны дүнд Булевиртид эмийг олон улсын зах зээлээс хэд дахин бага үнээр шууд худалдан авах хэлэлцээрт амжилттай хүрч,	2024.01.02-12.31

15/2/2



					хэлэлцээрийг 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан. Эхний ээлжийн эмийг 2024 оны 6 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авсан. Түүнээс хойш 2 удаа татан авалт хийгдсэн ба эмчилгээний явц байдлын талаар үйлдвэрлэгч, ХӨСҮТ, ЭМЯ гэсэн 3 талын цахим уулзалтыг 2024 оны 10 дугаар сард зохион байгуулав.	
3.	Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд гадаад улс орон, олон улсын байгууллагын техникийн туслалцааны шинэ төслийн санал боловсруулж, шийдвэрлүүлэх	Батлагдаж хэрэгжсэн төслийн тоо, санхүүжилтийн хэмжээ	Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газрын 5 сая ам.долларын төслийг батлуулан, хэрэгжүүлж эхэлсэн.	Шинээр хэрэгжүүлэх төсөл батлуулсан байна.	1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Санд эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн саналыг хүргүүлж, "КОВИД-19 халдвартай тэмцэх эм, эмчилгээний тоног төхөөрөмж, хэрэгслийн хангамжийг дэмжих АСТ-А SFF" механизмын нэмэлт санхүүжилтээр 706,323 ам.долларын холбогдох тоног төхөөрөмжийг нийлүүлэх төслийг батлуулсан. 2. ХБНГУ-ын Засгийн газраас Монгол Улсад олгосон хөнгөлөлттэй зээлийн 34 сая евро/29 сая ам.долларын өрийг Өр шилжүүлэх D2H санаачлагын хүрээнд эрүүл мэндийн салбарт зарцуулах болсны дагуу Глобаль санд төслийн саналыг боловсруулж хүргүүлэхэд Эмчилгээний бүрэлдэхүүн хэсэгт элэгний гепатит Д вирусийн халдвартай иргэдэд	2024.01.02-12.31

102



					"Гурвалсан халдварыг тэглэх" стратегийн хүрээнд 2,3 сая ам.долларт АНУ-ын "Гилеад Сайэнсис Инк" компанийн Булевиртид эмийн эмчилгээг тусгайлан оруулж хүргүүлсэн. 3. Kerry Mining (Mongolia) Limited-ийн 1,0 сая ам.долларын санхүүжилт бүхий "Хавдрын эм худалдан авах" төслийг батлуулаад байна.	
4.	Төсөл хөтөлбөрийн мэдээний сангийн тогтмол үйл ажиллагааг хөтөлнө	Мэдээний сан бүрдүүлэх		Мэдээний санг бүрдүүлсэн байна.	Мэдээний санг тогтмол шинэчлэн, үйл ажиллагааг тогтмол хянан хөтөлсөн.	2024.01.02-12.31
Зорилт 3. "САЙД, ДЭД САЙД, ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, УДИРДЛАГАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, АППАРАТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭВИЙН ЯВУУЛАХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД						
1.	Дэлхийн эрүүл мэндийн ассамблейн 77 дугаар чуулганд оролцуулах	Чуулганд оролцсон тайлан	Жил бүрийн чуулганд оролцож, хэлэлцэх асуудлаар Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлдэг.	Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам"-д заасны дагуу бэлтгэл ажлыг хангаж, чуулганд оролцсон байна.	Дэлхийн эрүүл мэндийн ассамблейн 77 дугаар чуулганд оролцохтой холбоотойгоор төлөөлөгчдийн Ажлын удирдамж, Эрхийн үнэмлэхний төсөл зэргийг боловсруулж, чуулганы дэлгэрэнгүй хөтөлбөрийн хамт 2024 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 2/21940 дугаар албан бичгээр ГХЯ-нд хүргүүлж тус яамны саналыг авсан. ГХЯ-ны саналыг тусгаж, ажлын удирдамжийг батлуулсан ба Чуулганд оролцох төлөөлөгчдөд Гадаад харилцааны сайдын гарын үсэг бүхий Эрхийн үнэмлэхийг гаргуулж, цахим бүртгэлийг гүйцэтгэсэн. Чуулганы нэгдсэн	2024.01.02-06.30

184



					хуралдаанд Монгол Улсаас Швейцарийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, НҮБ-ын Женев дэх төв болон бусад олон улсын байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн хэлэх үгийн төслийг англи хэлээр боловсруулж бэлтгэсэн ба ДЭМБ-ын холбогдох газарт мөн эх бичвэрийг журмын дагуу хүргүүлсэн. Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлж үг хэлж оролцсон. Ажлын удирдамжид заасны дагуу Чуулганы А хорооны хуралдаанаар авч хэлэлцсэн асуудлаар Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлсэн. Чуулганд оролцсон дүнгийн тухай илтгэх хуудсыг 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр ГХЯ болон Байнгын төлөөлөгчийн газарт цахим шуудангаар хүргүүлэв.	
2.	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн хорооны 75 дугаар чуулганд оролцуулах	Чуулганд оролцсон тайлан	Жил бүрийн чуулганд оролцож, хэлэлцэх асуудлаар Монгол Улсын Засгийн газрын байр	Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам"-д	Эрүүл мэндийн сайд тэргүүтэй төлөөлөгчид 2024 оны 10 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Филиппин Улсын Манила хотноо хуралдсан ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн хорооны 75 дугаар чуулганд оролцсон. Чуулганд оролцохтой холбогдуулан танилцуулга, ажлын	2024.08.01-12.31

			суурийг илэрхийлд эг.	заасны дагуу бэлтгэл ажлыг хангаж, чуулганд орлцсон байна.	удирдамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл зэргийг боловсруулж Гадаад харилцааны сайдад албан бичгээр хүргүүлэн саналыг авч тусган, эцэслэсэн. Улмаар ЗГХЭГ-т албан бичгээр хүргүүлж, Эрүүл мэндийн сайдын албан томиолотыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, ажлын удирдамжийг Ерөнхий сайдаар батлуулсан. Чуулганаар хэлэлцэн баталсан "Номхон далайн бүсэд эрүүл мэндийн санхүүжилтийг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээ", "Номхон далайн баруун бүсэд цахим эрүүл мэндийг ашиглах стратеги" зэрэг чиглэлээр Номхон далайн баруун бүсийн улс орнуудад урт хугацаанд баримтлах-стратегийн-баримт-бичгүүдийн төслүүдийн хэлэлцүүлэг тус бүрт Монгол Улс оролцож байр сууриа илэрхийлэв. Чуулганд оролцсон дүнгийн тухай илтгэх хуудас, хуралдаанд хэлсэн үг зэргийг хавсаргаж, ажлын 3 хоногт багтаан 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 3/4400 албан бичгээр ГХЯ-нд хүргүүлсэн болно.	
--	--	--	-----------------------------	--	--	--



3.	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай 2024-2028 онд хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратегийг боловсруулах	Батлагдсан стратеги	-	Хамтын ажиллагааны стратегийг боловсруулж, батлуулсан байна.	Монгол Улсын Засгийн газар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай 2024-2028 онд хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратегийг эцэслэн батлахтай холбогдуулан зөвлөлдөх уулзалтыг 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр холбогдох эрүүл мэндийн байгууллагуудыг оролцуулан хэлэлцүүлэг хийж, баримт бичгийг эцэслэсэн. Эрүүл мэндийн сайд С.Чинзориг ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн захирал Др.Саиа Ма'у Пиукала нар хамтын ажиллагааны стратегийн баримт бичигт 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан.	2024.01.02-12.31
4.	Олон улсын атомын энергийн агентлаг, Олон улсын хавдар судлалын агентлаг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран Монгол Улсын хорт хавдрын хяналтын чадавхид цогц үнэлгээ хийлгэх	Үнэлгээний тайлан	НҮБ-ын Олон улсын атомын энергийн агентлагтай Улс орныг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх "Монгол Улсад хорт хавдрын менежмент"	Үнэлгээ хийгдэж, дүгнэлт, зөвлөмж танилцуулагдсан байна.	Олон улсын атомын энергийн агентлаг, Олон улсын хавдар судлалын агентлаг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хамтарсан баг 2024 оны 1-4 дүгээр сард үндэсний экспертүүдтэй цахимаар баримт бичгийн үнэлгээ хийх болон Монгол Улсад 2024 оны 5 дугаар сарын 5-10-ны өдрүүдэд биетээр хийсэн үнэлгээний ажлыг зохион байгуулж ажиллав. Олон улсын үнэлгээний баг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж, хавдрын тусламж,	2024.01.02-12.31



			тийг сайжруулах" техникийн туслалцааны төслийн саналыг боловсруулж, ОУАЭА батлан хэрэгжүүлж эхэлсэн.		үйлчилгээний ажиллагаатай танилцаж, үнэлгээний багийн зүгээс урьдчилсан үнэлгээ, зөвлөмж, дүгнэлтийг Эрүүл мэндийн яамны удирдлагын түвшинд мөн үндэсний экспертүүдэд тусгайлан танилцуулсан. Үнэлгээний эцсийн дэлгэрэнгүй тайлан, зөвлөмж, дүгнэлтийг Олон улсын атомын энергийн агентлагаас 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авч, улмаар Эрүүл мэндийн сайдын 2024 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 1а/3569 дүгээр албан бичгээр төрийн холбогдох 8 байгууллагад хүргүүлж, тайланд тусгах саналыг нэгбүрчлэн авсан. Байгууллагуудаас ирүүлсэн саналуудыг судлан, ангилж нэгтгэн ОУАЭА-т-2024-оны-10 дугаар сарын 14-ний өдөр хүргүүлсэн.	
5.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагуудтай тус тусын мандатын хүрээнд хамтран ажиллах	НҮБ-ын төрөлжсөн байгууллагатай хамтран үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн байна.	2023 онд ДЭМБ, Хүүхдийн сан, Хүн амын сантай мандатын хүрээнд идэвхитэй хамтран ажилласан	Олон талт хамтын ажиллагаа өргөжиж, салбарын хэрэгцээ шаардлагад нийцсэн үр дүнтэй үйл ажиллагаануудыг хамтран	1. Монгол Улсад өвөлжилт хүндэрч, зудын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан тус хэлтсээс шуурхай арга хэмжээ авч, ДЭМБ-ын Суурин төлөөлөгчийн газар болон Номхон далайн баруун бүсийн төв штабд нөхцөл байдлыг танилцуулж, үнэлүүлэн, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нэн	2024.01.02-12.31

128



				хэрэгжүүлсэн байна.	шаардлагатай 911,827,563 төгрөгийн үнэ бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн захиалга өгч, шуурхай хүлээн авч холбогдох орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн. 2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газраас зудын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламжийн хүрээнд 195,000,000 төгрөгийн үнэ бүхий тарилгын шингэний хэм тогтворжуулагч термостатыг Эрүүл мэндийн сайдын А/44 дүгээр тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. 3. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол Улс дахь Суурин-төлөөлөгчийн газраас зудын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламжийн хүрээнд 326,000,000 төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн бүлээцүүлэх хөнжлийн 100 багцыг Эрүүл мэндийн сайдын А/60 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. 4. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газраас зудын нөхцөл	
--	--	--	--	------------------------	---	--

_____ to



				байдалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламжийн хүрээнд 110,827,563 төгрөгийн үнэ бүхий яаралтай тусламжийн багц болон ус цэвэршүүлэгч шахмалыг Эрүүл мэндийн сайдын А/120 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. 5. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газраас зудын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламжийн хүрээнд 280,000,000 төгрөгийн үнэ бүхий эмийн багцыг Эрүүл мэндийн сайдын А/142 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад олгосон. 6. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 20 эмч, мэргэжилтнүүдийг Харвардын анагаах ухааны их сургуулийн "Эрүүл мэндийн салбар дахь манлайлал" сэдэвт хөтөлбөрт хамруулсан. 7. Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, хянах бодлогын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Хүний папиллома вирусийн зонхилон тохиолдох 14 дэд хэв шинжийн ДНХ-г ялган оношлох тест китийг хангах нийлүүлэх,	
--	--	--	--	---	--

01/11

					тээвэрлэхэд шаардлагатай 210.000 ам.долларын санхүүжилтийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газраас шийдвэрлүүлсэн. Тест кит 12 дугаар сард нийлүүлэгдэнэ. 8. 2024-2025 оны өвөлжилтийн бэлэн байдлыг салбарт хангах, түнш байгууллагуудыг мэдээллээр хангах, нэмэлт санхүүжилт бий болгох зорилгоор 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр НҮБ-ын Суурин зохицуулагчтай хамтран НҮБ-ын төрөлжсөн агентлагууд, донор улсуудын элчин сайдын яамд, хөгжлийн хамтын ажиллагааны агентлагуудыг оролцуулсан "Эрүүл мэндийн баг"-ийн уулзалтыг зохион байгуулав. Уулзалтаар өвөлжилтийн нөхцөл байдал, зудын эрсдлийг түншүүдэд танилцуулж, үүнтэй холбоотойгоор нэн яаралтай болон дунд хугацаанд шийдвэрлэх шаардлагатай эд материал, мөнгөн санхүүжилтийн хэрэгцээг тодорхойлон НҮБ-ын Хүмүүнлэгийн багт хүргүүлэв.	
6.	Монгол Улс, БНСУ-ын Эрүүл мэндийн яамд хоорондын ээлжит зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, Эрүүл мэндийн яамд хоорондын хамтын	БНСУ-ын Эрүүл мэндийн яамтай уулзалт	-	Хамтын ажиллагааны механизмын хүрээнд тодорхой үр	Эрүүл мэндийн сайд С.Чинзориг БНСУ-ын Эрүүл мэнд, нийгмийн халамжийн сайд Жү Гюү Хуны урилгаар тус улсад 2024 оны 3 дугаар	2024.01.02-12.31

2024



	ажиллагааны механизмыг идэвхтэй болгох	зохион байгуулсан байна.		дүнтэй ажлуудыг шинээр санаачилж хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.	сарын 14-15-ны өдрүүдэд ажлын айлчлал хийв. Энэхүү айлчлалын үеэр сайд С.Чинзориг, БНСУ-ын Эрүүл мэнд, нийгмийн халамжийн Дэд сайд хатагтай Ким Хэ-жин нар 3 дугаар сарын 15-ны өдөр хоёр талын уулзалтыг хийсэн. Уулзалтаар манай талаас i)"Сөүл Төсөл"-ийн үйл ажиллагааг сэргээх, тухайлбал, ii)монголын эмч мэргэжилтнүүдэд зориулж солонгосын эмнэлгүүдэд зохион байгуулдаг эмнэлзүйн сургалтыг сэргээх, iii)БНСУ-д эмчилгээнд хамрагдсан монгол иргэдийн эрүүл мэндийн байдалд монголоос телемедицины арга технологийг ашиглан хяналт тавьдаг "Эмчилгээний дараах хяналтын төв"-үүдийн үйл ажиллагааг сайжруулах, iv)2011 онд байгуулсан хоёр улсын Эрүүл мэндийн яамд хоорондын тохиролцоог шинэ утга агуулгаар баяжуулан шинэчлэн байгуулах, v)эмийн шууд худалдан авалт зэрэг чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцов.	
					2024 оны 8 дугаар сараас эхлэн БНСУ-ын топ 20 эм үйлдвэрлэгчидтэй эмийн үнийн хэлцэл хийж, 2024 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн	

14

					байдлаар Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт хамгийн ихээр олгодог ерөнхий нэршлийн 18 нэрийн эмийн үнийг тохирч, ханган нийлүүлэлтийн хэлэлцээрийг үйлдвэрлэгч нартай эцэслэн тохиролцов. Эхний ханган нийлүүлэлтийн гэрээний хүрээнд 1 үйлдвэрлэгчийн 5 нэрийн эм 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсад импорлогдон ирсэн.	
7.	Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Эрүүлийг хамгаалах, анагаах ухааны салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг шинэчлэх	Шинэчлэгдсэн хэлэлцээр	Хэлэлцээрийг шинэчлэхтэй холбоотой яриа хэлэлцээг хийсэн байна.	Хэлэлцээрийг шинэчлэн батлуулсан байна.	Монгол Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг Оросын Холбооны Улсын Эрүүлийг хамгаалахын сайд М.А.Мурашкогийн урилгаар тус улсын Бүгд Найрамдах Буриад Улсын нийслэл Улаан-Үд хотноо 2024 оны 02 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд ажлын айлчлал хийсэн. Айлчлалын үеэр Сайд С.Чинзориг, ОХУ-ын сайд М.А.Мурашко нарын хоёр талын уулзалтын үеэр Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэн батлах талаар манай талаас саналаа дэвшүүлсэн боловч айлын талаас дээрх хэлэлцээрийг шинэчлэх шаардлагагүй, түүнчлэн уг асуудлыг ОХУ-ын ГХЯ шийдэх тул боломжгүй хэмээн мэдэгдсэн ба энэ тухай ярианы тэмдэглэлийн 6 дугаар	2024.01.02-12.31



					хуудаст тодорхой тэмдэглэгдсэн байгаа. Эл асуудлыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс хасуулах саналтай байгаа.	
8.	Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүл мэндийн үндэсний хороо хооронд 2023-2026 онд хамтран ажиллах Төлөвлөгөө байгуулж, эрүүл мэндийн салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэх	Батлагдсан төлөвлөгөө	Төлөвлөгөө байгуулахт ай холбоотой яриа хэлэлцээг айлын талтай хийсэн байна.	Төлөвлөгөөг шинэчлэн байгуулсан байна.	Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүл мэндийн үндэсний хороо хооронд 2023-2026 онд хамтран ажиллах Төлөвлөгөөг монгол, англи хэлээр боловсруулж, ГХЯ-ны Олон улсын гэрээ эрх зүйн газраас хянуулж, байгууллага хоорондын гэрээ байгуулах журамд заасны дагуу холбогдох зөвшөөрлийг тус яамнаас авсан. Манай талаас тус улсад ажлын айлчлал хийж, төлөвлөгөөг байгуулах тухай албан бичгийг ГХЯ-аар дамжуулж-хүргүүлсэн.-Айлын талаас тус улсын Эрүүл мэндийн сайд 2023 оны 12 дугаар сараас хойш удаан хугацаанд эзгүй байгааг дурьдаж, манай сайдыг хүлээн авах боломжгүй байгааг тайлбарласан хариуг ирүүлсэн. Улмаар 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдөр шинэ сайд томилогдсон тухай бидэнд дипломат шугамаар мэдээлсэн. Үүний мөрөөр сайд С.Чинзоригоос ЛЭЙ ХАЙЧАО сайдад баяр хүргэсэн албан	2024.01.02-12.31

УМГ

					захидал хүргүүлж, төлөвлөгөөнд гарын үсэг зурах тухай саналаа дахин дэвшүүлсэн. Энэ саналын хариуд БНХАУ-ын шинээр томилогдсон Эрүүл мэндийн үндэсний хорооны дарга сайд манай улсад албан ёсны айлчлал хийж, энэ үеэр баримт бичгийг байгуулах саналтай байгаагаа Бээжин дэх манай улсын ЭСЯ-аар дамжуулж 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр E/02/24/1323 дугаартай цахим шуудангаар ирүүлсэн ба манай талаас дэмжсэн хариуг хүргүүлсэн.	
9.	Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улс хоорондын эрүүл мэндийн салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэх	Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулагдаж, хэлэлцээрийн хүрээнд тодорхой үйл ажиллагаа хэрэгжсэн байна.	-	Хоёр улсын эрүүл мэндийн яам хоорондын уулзалтыг зохион байгуулсан байна.	“Эрүүл мэнд, анагаахын шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Улаанбаатар, Анкара хотноо 2024-оны 3 дугаар сарын 21 болон 5 дугаар сарын 20-ны өдөр тус тус гарын үсэг зурж байгуулсан. Энэхүү хэлэлцээр нь талууд тус тусын дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг гүйцээж, дипломат шугамаар харилцан мэдэгдсэнээр хүчин төгөлдөр болох тул Олон улсын гэрээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасны дагуу “Хэлэлцээр	2024.01.02-12.31



					батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, бүх яамдаас санал авсан. Улмаар Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанд асуудлыг хэлэлцүүлж, “Хэлэлцээр батлах тухай” 64 дүгээр тогтоолыг батлуулсан. Монгол Улсын Эрүүл мэндийн яам, БНТУ-ын Эрүүл мэндийн яам хооронд Ажлын хэсгийн анхдугаар уулзалтыг цахимаар амжилттай зохион байгуулж, хамтран ажиллах чиглэлүүдээ тодорхойлсон. Айлын талаас манай яамны Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тус улсад ажлын айлчлал хийхийг урьсан байгаа.	
10.	Бүгд Найрамдах Солонгос Улсын Өвчний хяналт, сэргийлэлтийн агентлагтай хамтран ажиллах үндэс суурийг тавих	Хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бий болгож, хамтран ажиллах чиглэлүүдийг тодорхойлсон байна	-	Бүгд Найрамдах Солонгос Улсын Өвчний хяналт, сэргийлэлтийн агентлагтай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан байна.	Монгол Улсын Эрүүл мэндийн яам, БНСУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн агентлаг хооронд Нийгмийн эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг монгол, англи хэлээр боловсруулж, ГХЯ-ны Олон улсын гэрээ эрх зүйн газраас хянуулж, санамж бичгийг байгуулах зөвшөөрлийг албан ёсоор авсан. Үүний дараа Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболд 2024 оны 2 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Өвчний хяналт сэргийлэлтийн	2024.01.02-12.31

924



					агентлагт айлчлал хийх үеэр Санамж бичгийг байгуулсан.	
11.	Эрүүл мэндийн яамны гадаад хамтын ажиллагааны 2023 оны үйл ажиллагааны бичмэл тайланг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх	Эрүүл мэндийн салбарын гадаад хамтын ажиллагааны тайлан ГХЯ-нд хүргэгдсэн байна.	Хугацаанд нь жил бүр хүргүүлдэг	Эрүүл мэндийн салбарын 2022 оны гадаад хамтын ажиллагааны тайланг 2024 оны 1 дүгээр сарын эхний 7 хоногт багтаан ГХЯ-нд хүргүүлсэн байна.	Эрүүл мэндийн яамны гадаад хамтын ажиллагаана 2023 оны үйл ажиллагааны бичмэл тайланг 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр 2/26 дугаар албан бичгээр ГХЯ-нд 10 хуудас тайланг хавсарган хүргүүлсэн.	2024.01.02-12.31
12.	Гадаад улсуудын болон олон улсын байгууллагын шугамаар сургалт, хурал семинарт оролцох хүмүүсийн холбогдох материалыг судалж, шийдвэрлэх, хамруулах	Шийдвэрлэсэн асуудлын тоогоор илэрхийлэгдсэн байна.	2023 онд 423 эрүүл мэндийн ажилтныг сургалтад хамруулсан.	Эрүүл мэндийн салбарын бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх түвшний албан хаагчдыг хамруулсан байна.	2024 оны жилийн эцсийн байдлаар 161 албан хаагчдыг гадаад улс болон олон улсын байгууллагын шугамаар сургалт семинарт хамруулсан. Үүнд: 1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулагдсан урт болон богино хугацааны сургалт, хурал, семинарт нийт 101 албан хаагчийг хамруулсан. 2. НҮБ-ын Хүүхдийн сангаас зохион байгуулсан богино хугацааны хурал, семинарт 5 албан хаагчийг хамруулсан. 3. Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлагаас зохион байгуулсан	2024.01.02-12.31

44



				богино, дунд хугацааны сургалтад 10 албан хаагчийг хамруулхаар нэр дэвшүүлээд байна. Сургалт 2024 оны 6 болон 9 дүгээр саруудад тус тус зохион байгуулагдана. 4. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Жянгсу мужийн Хяналт, шалгалтын байгууллагаас 2024 оны 9 дүгээр сарын 12-25-ны өдрүүдэд Чанжоу хотноо зохион байгуулж буй "Хилийн боомт дахь халдвар хамгааллын дэглэм" сэдэвт семинар 3 албан хаагчийг хамруулав. 5. Оросын Холбооны Улсын Эрүүлийг хамгаалах яамнаас зохион байгуулсан Хүүхдийн яаралтай тусламж сэдэвт сургалтад 9 эмчийг хамруулхаар нэр дэвшүүлээд байна. Сургалт 2024 оны 11 дүгээр сард зохион байгуулагдах болно. 6. Оросын Холбооны Улсын Эрүүлийг хамгаалах яамнаас зохион байгуулсан Хүүхдийн өвчлөл ба Халдварт өвчин сэдэвт сургалтад 9 эмчийг 2024 оны 10 дугаар сарын 7-19-ний өдрүүдэд хамруулав. 7. Бүгд найрамдах Хятад Ард Улсын Худалдааны яамнаас 2024 оны 11 дүгээр сарын 1-21-ний өдрүүдэд Ху Нань мужийн Цанша хотноо	
--	--	--	--	--	--

2024



					зохион байгуулагдах "Яаралтай тусламж, сэргээн засах чадавхыг дээшлүүлэх" сургалад 24 эмчийг хамруулав.	
13.	Гадаад улс орнууд, олон улсын байгууллага болон олон улсын төрийн бус байгууллагуудтай хийгдэх уулзалт, ярианы тэмдэглэл хөтлөх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Хянагдаж гарсан уулзалтын ярианы тэмдэглэлийн тоо гарсан байна.	2023 оны 23 ярианы тэмдэглэл ийг хянан баталгааж уулсан.	Уулзалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавигдсан байна.	2024 оны жилийн эцсийн байдлаар дараах 32 гадаад албан уулзалтыг зохион байгуулж, уулзалтын тэмдэглэлийг хөтлөн, ажлын 3 хоногт багтаан хүлээн авч уулзсан албан тушаалтнаар гарын үсэг зуруулан, уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, холбогдох газар, хэлтсийн дарга нарт хүргүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллалаа. Үүнд: 1. Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суух онц бөгөөд бүрэн эрхт—Элчин—сайд—Шинь Мэньжуанг хүлээн авч уулзсан уулзалтын тэмдэглэл хөтлөв. 2. Эрүүл мэндийн сайд С.Чинзориг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын замын хөдөлгөөний Тусгай элч Жан Тодтыг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 3. Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Бельгийн Хаант Улсаас Монгол Улсыг хавсран суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Бруно Анжелиг	2024.01.02-12.31



					хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 4. Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Люксембургийн Их Гүнт Улсаас Монгол Улсыг хавсран суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Ролонд Рейландийг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 5. Эрүүл мэндийн сайд С.Чинзориг ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн Захирал Др.Саиа Ма'у Пиукалаг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 6. Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суух онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Чой Жин Вонг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв.	
					7. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан НҮБ-ын Хүүхдийн сангийн Суурийн төлөөлөгч ноён Эваристе Коуасси Комланг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 8. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан НҮБ-ын Хүн амын сангийн Тэргүүн Др. Халид Шарифиг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв.	



					9. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Азийн хөгжлийн банкны Зүүн, Зүүн өмнөд ази болон Номхон далайн бүсийг хариуцсан Дэд ерөнхийлөгч ноён Скотт Моррисыг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 10. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан НҮБ-ын Хүүхдийн сангийн Зүүн ази Номхон далайн Бүсийн захирал Жьон Кунугиг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 11. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Орбис интернэйшнл байгууллагын Ерөнхийлөгч Дерек Ходгкиг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 12. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Азийн хөгжлийн банкны—Монгол—Улс—дахь Суурин төлөөлөгч Шаннон Ковлиныг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 13. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Бүгд Найрамдах Солонгос Улсын талаас Элчин сайд Чой Жин Воныг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 14. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Айчи Гакүин Их сургуулийн Профессор Нацүмэ Нагатог хүлээн авч уулзах	
--	--	--	--	--	--	--

					уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 15.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Айчи Гакүин Их сургуулийн Профессор Нацүмэ Нагаторо хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 16.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Суурин төлөөлөгч Др.Сокорро Эскалантэг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 17.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Лаурэл мэс заслын сангийн талаас олон улсын хөтөлбөр хариуцсан дарга Хью Парсонсыг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 18.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Бүгд Найрамдах Турк—Улсаас—Монгол—Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Зафер Атеш, ТИКА-ын Суурин төлөөлөгч Эмрах Устаөмэр нарыг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 19.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан ЖАЙКА- Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын дарга ноён Танака Шиничи, шинэ дарга ноён Мияги Кэнсүкэ нарыг хүлээн	



					авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 20.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан АНУ-ын Нью-Йорк хотноо хуралдсан НҮБ-ын Ерөнхий ассамблейн өндөр түвшний уулзалтын үеэр ДЭМБ-ын Ерөнхий захирал Др. Тедрос А. Гебрейесустай уулзсан уулзалтын ярианы тэмдэглэлийг хөтлөж, баталгаажуулав. 21.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан АНУ-ын Нью-Йорк хотноо хуралдсан НҮБ-ын Ерөнхий ассамблейн өндөр түвшний уулзалтын үеэр ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн захирал Др. Саиа Ма'у Пиукалаг хүлээн авч уулзсан уулзалтын ярианы тэмдэглэлийг хөтлөж, баталгаажуулав. 22.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан-АНУ-ын-Өвчний-хяналт сэргийлэлтийн агентлагийн Токио дахь оффисын Бүсийн захирал Мишел МакКоннелийг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 23.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Дэлхийн банкны Монгол Улсыг хариуцсан менежер бөгөөд Суурийн төлөөлөгч Таехюн Лиг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв.	



					24.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан ОХУ-ын талаас Хүний эрүүл мэнд, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах холбооны хяналтын газрын дарга, тус улсын Ерөнхий эрүүл ахуйч эмч Анна Юрьевна Поповаг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 25.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Азийн хөгжлийн банкны Зүүн, Зүүн Өмнөд Ази болон Номхон далайн бүсийг хариуцсан Дэд ерөнхийлөгч ноён Скотт Моррисийг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 26.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Кувейтийн сангийн Ерөнхий захирлын үүрэг гүйцэтгэгч Валийд Шамлан Аль-Бахрыг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж-тэмдэглэл хөтлөв.	
					27.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Бүгд Найрамдах Филиппин Улсын Эрүүл мэндийн газраас Ерөнхий нарийн бичгийн дарга Др. Теодоро Ж.Хербосаг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 28.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлагийн талаас Монгол Улсыг хариуцсан захирал Райан Уашбурныг	



					хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 29.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан НҮБ-ын Монгол Улс дахь Суурин зохицуулагч Талан Мишраг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 30.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Австралийн Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Кэйти Смитийг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 31.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Ина Марчюлёнитег хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв. 32.Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан Глобал сангийн Монгол Улсыг хариуцсан менежер Аллан Нфамба, Монгол Улсыг хариуцсан шинэ менежер Химена Навиа нарыг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулж тэмдэглэл хөтлөв.	
14.	Гадаад улс орон, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах, сунгах асуудлыг судлан шийдвэрлэх	Шийдвэрлэсэн асуудлын тоогоор илэрхийлэгдсэн байна.	2023 он 11 баримт бичгийг сунгах, шинэчлэх,	Эрүүл мэндийн салбар дахь гадаад хамтын ажиллагаа өргөжиж,	2024 оны жилийн эцсийн байдлаар дараах 9 баримт бичиг байгуулах, сунгуулж байгуулав.	2024.01.02-12.31



			шинээр байгуулах ажлыг гүйцэтгэсэ н	салбарын хөгжилд түлхэц үзүүлнэ.	1. Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Олон улсын хавдрын зөвлөлийн АТОМ олон улсын төрийн бус байгууллагатай хорт хавдрын эмийн зохистой хэрэглээ, хангамжийн чиглэлээр хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг боловсруулан, хянаж эцэслэн 2024 оны 2 дугаар сард байгуулав. 2. Монгол Улсын Эрүүл мэндийн яам, БНСУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн агентлаг хооронд Нийгмийн эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг 2024 оны 2 дугаар сард байгуулав. 3. Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хоорондын 2024-2028-онд хамтран ажиллах хамтын ажиллагааны стратегийн баримт бичигт 2024 оны 4 дүгээр сард гарын үсэг зурж байгуулав. 4. Эрүүл мэндийн яам, Орбис Интернэйшнл олон улсын байгууллага хоорондын хамтын ажиллагааны санамж бичгийг 2024 оны 4 дүгээр сард шинэчлэн байгуулав. 5. Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Эрүүл мэндийн яам хоорондын	



					хамтын ажиллагааны санамж бичгийг 2024 оны 6 дугаар сард шинэчлэн байгуулав. 6. Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Бутаны Хаант Улсын Эрүүл мэндийн яам хоорондын Уламжлалт анагаах ухааны салбарт хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичгийг 2024 оны 7 дугаар сард шинээр байгуулав. 7. “Эрүүл мэнд, анагаахын шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг шинэчлэн байгуулж, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанд хэлэлцүүлж, “Хэлэлцээр батлах тухай” тогтоолыг-батлуулав.	
					8. Тарваган тахал өвчний тархвар судлалын чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон Оросын Холбооны Улсын Хүний эрүүл мэнд, хэрэглэгчийн эрхийг хамгаалах холбооны хяналтын газар хоорондын хэлэлцээр”-ийг 2024 оны 9 дүгээр сард шинэчлэн байгуулав. 9. Эрүүл мэндийн яам Япон Улсын Олон улсын эрүүл мэнд, халамжийн их сургууль	



					хооронд хамтран ажиллах тухай хэлэлцээрийг 2024 оны 9 дүгээр сард шинээр байгуулав.	
15.	Гадаад улс орнууд, олон улсын байгууллагуудтай хийгдэх ёслолын арга хэмжээг зохион байгуулах	Шийдвэрлэсэн асуудлын тоогоор илэрхийлэгдсэн байна.	2023 онд ёслолын арга хэмжээ 10-ыг зохион байгуулсан	Ёслолын арга хэмжээ журмын дагуу зохион байгуулагдсан байна.	2024 оны жилийн эцсийн байдлаар дараах 5 ёслолын арга хэмжээг зохион байгуулав. 1. Монгол Улсын Эрүүл мэндийн яам, БНСУ-ын Өвчний хяналт, сэргийлэлтийн агентлаг хооронд Нийгмийн эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулах ёслолын арга хэмжээг зохион байгуулав. 2. Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хоорондын 2024-2028 онд хамтран ажиллах хамтын ажиллагааны стратегийн баримт бичигт гарын үсэг зурах ёслолын ажиллагааг зохион байгуулав. 3. Эрүүл мэндийн яам, Орбис Интернэйшнл олон улсын байгууллага хоорондын хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэн байгуулах ёслолын арга хэмжээг зохион байгуулав. 4. Азийн хөгжлийн банкаар дамжин Ядуурлыг Бууруулах Японы Сан (JFPR)-гийн 5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй	2024.01.02-12.31



					"Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхийг бэхжүүлэх" төслийн хүрээнд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, оношилгоо, шинжилгээ хийхээр бүрэн тоноглогдсон нүүдлийн эмнэлэг бүхий 4 тусгай зориулалтын автомашиныг хүлээлгэн өгөх ёслолын арга хэмжээг зохион байгуулав. 5. Орбис нүдний нисдэг эмнэлэг хөтөлбөрийн нээлтийн ёслолын үйл ажиллагааг зохион байгуулав.	
16.	Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарын гадаадын улс орнуудад хийх айлчлал, хурал семинарт оролцох бэлтгэлийг хангаж, зохион байгуулах	Хэрэгжсэн айлчлал, хурал семинарын тоогоор илэрхийлэгдсэн байна.		Айлчлал, хурал семинарт оролцож, хэрэгжүүлэх үйл ажиллагаа тодорхойлогдсон байна.	1. Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболдын 2024 оны 2 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Өвчний хяналт сэргийлэлтийн агентлагт хийх айлчлалыг зохион байгуулж ажиллав. 2. Эрүүл мэндийн сайд С.Чинзориг ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсад 2024 оны 2 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд хийсэн ажлын айлчлалыг зохион байгуулав. 3. Эрүүл мэндийн сайд С.Чинзориг БНСУ-ын Эрүүл мэнд, халамжийн сайдын урилгаар 2024 оны 3 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд тус улсад хийсэн ажлын айлчлалыг зохион байгуулав.	2024.01.02-12.31



					4. Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбатын 2024 оны 4 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Филиппин Улсад Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын техникийн зөвлөлдөх долоодугаар хуралд оролцох ажлыг зохион байгуулж ажиллав. 5. Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбатын 2024 оны 4 дүгээр сарын 27-ноос 5 дугаар сарын 1-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүнс, эмийн аюулгүй байдлын яаманд хийх айлчлалыг зохион байгуулж ажиллав. 6. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханы 2024 оны 9 дүгээр сарын 22-ноос 24-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсад хийсэн ажлын айлчлалыг зохион байгуулж ажиллав.	
					7. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханы 2024 оны 9 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотноо зохион байгуулагдах Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 79 дүгээр чуулганы Ерөнхий санал шүүмжлэлийн хүрээнд болох "Нянгийн тэсвэржилт"-ийн асуудлаарх Өндөр түвшний уулзалтад оролцох ажлыг зохион байгуулж ажиллав.	

					8. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханы 2024 оны 10 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн хорооны 75 дугаар чуулганд оролцох бэлэн байдлыг хангаж, зохион байгуулж ажиллав. 9. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханы 2024 оны 11 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын "Ансей Сан"-гаас "Кореа Хералд Медиа Групп"-тэй хамтран зохион байгуулсан "Монгол-Солонгосын хамтын ажиллагааны ирээдүйн стратеги" форумд оролцох бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулж ажиллав.	
17.	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, төлөвлөгөөний биелэлт, тайлан мэдээг нэгтгэн гаргах	Шийдвэрлэсэн асуудлын тоогоор илэрхийлэгдсэн байна.	Хууль тогтоомжийн биелэлтийг хугацаанд нь тогтмол гаргадаг.	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, төлөвлөгөөний биелэлт, тайлан мэдээг нэгтгэн гаргаж, холбогдох нэгжүүдэд хүргүүлэн биелэлтэд тавих хяналт сайжирсан байна байна.	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, төлөвлөгөөний биелэлт, тайлан мэдээг нэгтгэн цаг тухай бүрт холбогдох газруудад тогтмол хүргүүлэн ажиллав.	2024.01.02-12.31



**Зорилт 4. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

1.	Төрийн албаны тухай хуулийн 37-р зүйлийн 37.1.8-д заасны дагуу "Өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх" нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллана.	Нийтлэг үүргээ зөрчилгүйгээр хэрэгжүүлсэн байна.	Төрийн албаны хууль тогтоомжийг мөрдлөг болгож ажилладаг.	Төрийн албаны тухай хуулийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллана.	Төрийн албаны нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	2024.01.02-12.31
2.	2023 оны харилцсан баримт бичгийг архивт хугацаанд хүлээлгэн өгнө.	Хугацаанд нь баримт бичгийг хөтлөх хэргийн жагсаалтын дагуу бүрдүүлэн байгууллагын архивт бүрэн бүрдэлтэй шилжүүлэн өгсөн байна.	Жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан харилцсан бичгийг Архивын эрхлэгчид хүлээлгэж өгдөг.	2023 онд харилцсан холбогдох баримт бичгийг хөтлөх хэргийн жагсаалтын дагуу байгууллагын архивт бүрэн бүрдэлтэй шилжүүлэн өгнө	2023 онд харилцсан баримт бичгийг журмын дагуу архивын бүрдэл үүсгэн заасан хугацаанд архивд хүлээлгэн өгч ажиллав.	2024.01.02-12.31

ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)

Д/д	Үүрэг даалгавар	Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Биелэлт
-----	-----------------	---	------------------	--------------	--------------	---------

182

○

○


○

1.	Үүрэг даалгавар Арга хэмжээ 1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн захирал Др.Саиа Ма'у Пиукалагийн Монгол Улсад хийх айлчлалыг зохион байгуулах	Эрүүл мэндийн сайд С.Чинзориг	Айлчлал амжилттай хэрэгжсэн байна.	-	Айлчлал хэрэгжиж, хамтын ажиллагаа стратегийг тодорхойлсон байна.	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн Захирал Др. Саиа Ма'у Пиукала 2024 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрүүдэд Монгол Улсад айлчлав. Айлчлалын хөтөлбөрийг Эрүүл мэндийн сайдаар, төсвийг ТНБД-аар батлуулж, хэрэгжүүлэв. Айлчлалын хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хоорондын 2024-2028 онд хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны стратегийн баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулав. Биелэлт: 100%
2.	Орбис нүдний нисдэг эмнэлэг хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн сайд С.Чинзориг	Орбис нүдний нисдэг эмнэлэг хөтөлбөрийг хугацаанд эхлүүлсэн байна.		Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн байна.	Орбис нүдний нисдэг эмнэлэг хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Эрүүл мэндийн яам, Орбис Интернэйшнл олон улсын байгууллага хоорондын хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэн байгуулсан. 2024 оны 8 дугаар сарын 1-26-ны өдрүүдэд үзлэг, мэс заслын эмчилгээ хийж, монголын нүдний эмч, мэргэжилтнүүдэд мэс заслын гардан болон симуляци сургалт зохион байгуулах ажлуудын бэлтгэл байдлыг хангаж ажилласан. Орбис нүдний нисдэг эмнэлэг ирэхтэй холбогдуулан Зам, тээврийн яамнаас онгоцыг нисэх буудалд газардан ажиллах хугацаанд нисэх буудлын газрын үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөх, нисэх буудлын зүгээс шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зэрэг ажлыг зохион байгуулж ажиллав.



						Биелэлт: 100%
3.	Эрүүл мэндийн салбарын Удирдах ажилтны зөвлөгөөн болон Олон улсын эмч нарын өдөрт зориулсан "Эмч танаараа бахархъяа" арга хэмжээг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах,	Эрүүл мэндийн сайд С.Чинзориг	Зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулах	-	Зөвлөгөөн болон арга хэмжээг тус тус зохион байгуулсан байна.	Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж ажиллав. Олон улсын эмч нарын өдөрт зориулсан "Эмч танаараа бахархъяа" арга хэмжээг 2024 оны 3 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж ажиллав. Биелэлт: 100%
4.	Шуурхай удирдлагын төв (ЕОС)-ийг ЭМЯ-ны байранд шинээр байгуулах	Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан	Шуурхай удирдлагын төвийг байгуулсан байна.	-	Шуурхай удирдлагын төвийг ашиглалтад байна.	Шуурхай удирдлагын төв (ЕОС)-ийг ЭМЯ-ны байранд байгуулах шаардлага, үндэслэлийн төслийг боловсруулж, 2024 оны 8 дугаар сард Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлсэн. Үүнтэй холбогдуулан Номхон далайн баруун бүсийн төвөөс 2 удаа зөвлөх баг хүлээн авч ажиллуулсан ба барилгын ажил болон, мэдээлэл, технологийн тоног төхөөрөмжийн худалдан авалтын ажил хийгдэж байна. 12 дугаар сард ашиглалтад орно. Биелэлт: 100%
5.	ДЭМБ-ын цогц үнэлгээгээр эмийн хяналт, зохицуулалтын үндэсний байгууллагын чадавхи хамгийн өндөр түвшинд үнэлэгдсэн улсуудын эм үйлдвэрлэгчидтэй үнийн хэлцэл хийх, ханган нийлүүлэлтийн гэрээ байгуулах ажлыг гүйцэтгэх	Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан	Эмийн үнийн хэлцэл эцэслэгдэж, гэрээ байгуулагдсан байна.	-	Нэг эх үүсвэрийн худалдан авалтын хүрээнд Монгол Улсад эм импортлогд	2024 оны 8 дугаар сараас эхлэн БНСУ-ын топ 20 эм үйлдвэрлэгчидтэй эмийн үнийн хэлцэл хийж, 2024 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт хамгийн ихээр олгодог ерөнхий нэршлийн 18 нэрийн эмийн үнийг тохирч, ханган нийлүүлэлтийн

104




					ож худалдаанд гарсан байна.	хэлэлцээрийг үйлдвэрлэгч нартай эцэслэн тохиролцов. Эхний ханган нийлүүлэлтийн гэрээний хүрээнд 1 үйлдвэрлэгчийн 5 нэрийн эм 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсад импорлогдон ирсэн.
--	--	--	--	--	--------------------------------------	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	
	1	2	3	4	5	6
1.	Төрийн албаны шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар уншиж судлах, энэ чиглэлээр Удирдлагын академийн сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байна.	-	Сертификат авсан байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Удирдлагын академи, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хамтран зохион байгуулсан “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ” сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан.	2024.01.02-12.31

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГХАХ-ийн дарга
(Албан тушаал)

Б.Янжмаа /  /
(Нэр, гарын үсэг)

2024.12.02
(Огноо)

